

МОНГОЛ ҮГИЙН ЯЗГУУРЫН ТОЛЬ

Монгол хэлний үгийн бүтэц бүрэлдэхүүний талаар сүүлийн үед гарсан томоохон ажлын нэг нь залуу судлагч Сэцэнцогтын найруулан туурвисан «Монгол үгсийн язгуурын толь» юмаа. Энэхүү «Монгол үгсийн язгуурын толь»-ийг монгол хэл сурч судлагч хүмүүст лавлалт тусламж болгох зорилгоор Өвөр Монголын ардын хэвлэлийн хорооноос 1988 онд хэвлэн гаргажээ. Эл толь бичигт монгол хэлний эрт эдүгээгийн 30000 (3 түмэн) гаруй үгийг сонгон авч үндсэн толгой үг болгон оруулаад, эдгээр үгээ язгуур үндэс, дагавар тэргүүтнээр нь задалж гаргасны дээр 5000 орчим үгийн язгуур, 6000 шахам үүс мэл үндсийг задалж үзүүлсэн байна.

Ерөөс толь бичиг зохион туурвих нь хүнээс мэргэжлийн мэдлэг, эх хэлний мэдлэг, арга зүйн мэдлэг, уйгагүй хөдөлмөрч бүтээлч чанар, чадвар шаарддаг чимхлүүр, ярвигтай, хариуцлагатай ажил¹ гэдэг нь лавтай.

«Монгол үгсийн язгуурын толь» нь даруй 3000 шахам хуудас бүхий нэлээд том хэмжээтэй толь бичиг аж. Уг язгуурын тольд үгсийн хэсэг (1—2500 дугаар тал), монгол хэлний дагаврын хэсэг (2501—2949 дүгээр тал) гэсэн үндсэн хоёр хэсэг байгаагаас гадна гарагийн хүснэгт, билгийн улирлын 12 сарын нэрийтгэл, монгол тооны хүснэгт, эд эрхтний хүснэгт, равжун жарны нэрс, уйгуржин монгол үгсийн цагаан толгой, дөрвөлжин үгсийн цагаан толгой, тод үгсийн цагаан толгой, славжин (кирилл) монгол үгсийн цагаан толгой тэргүүтнийг хавсарган оруулсан байна. Энэхүү тольд үгийг бүтцээр нь задалж тайлбарлахдаа «Монголын нууц товчоо», «Рашид ад-Диний «Судрын чуулган», «Алтан товч», «Асрагч нэртнийн түүх», «Гэсэр», «Жангар», «Хөх судар» зэрэг уламжлалт дурсгалт бичиг болон бусад эх хэрэглэгдэхүүнээс холбогдох жишээ зүүлтийг сайтар ашигласан нь нэн сайшаалтай. Энэ нь үгийн утгыг бүрэн гүйцэд ойлгоход тус нэмэр болж өгчээ. Мөн монгол хэлний олон аялгууны болон төрөл алтай язгуурын түрэг, манж түнгүүс хэлний материалыг ч нэлээд хэмжээгээр ашиглажээ.

Монгол хэлний үгийн язгуур бүтээвэр үгийнхээ цөм болж, ямагт үгийн эхэнд нь байрлаж, үг бүтээх залгавар бүтээвэр авч шинэ үг бүтээхийн бааз суурь болдгоороо бусад бүтээврээс ялгаатайгаас гадна, тус бүр салангид, тоо ширхэгээр маш олон байдгаараа ялгаатай² билээ. Үгийн язгуур нь уул үгийн хамгийн ерөнхий утгыг хадгалсан үндсэн хэсэг байдаг. Нэг язгуурт (үгэнд олон янзын дагавар залгаж янз бүрийн үг үүсгэдэг бол бас олон янзын язгуурт нэг зүйлийн дагавар залгаж мөн олон янзын үгийг үүсгэдэг. Энэ учраас үгийн тооноос язгуурын тоо нь үлэмж цөөн, язгуурын тооноос дагаврын тоо бүр цөөн байна.³ Иймээс ч эл тольд уг бүтээх 544 дагаврыг жагсаан оруулсан байна. «Монгол үгсийн язгуурын толь»-д үгийг задалж язгуур бүтээврийг гаргахдаа залгаврын аргыг анхаарснаар барахгүй авианы хувирлаар үг бүтээх ёс монгол хэлэнд байдгийг мөн нэгэн адил анхаарчээ. Учир иймээс монгол хэлний үгийн язгуурын задлалтын талаар өнгөрсний (урьд өмнө нэгэнтээ гарсан) хэл зүйн ном судар, толь бичгээс нэг алхам гүнзгийрсэн⁴ хэмээн хэвлэн нийтлэгчээс тэмдэглэсэн байна. Ер нь энэхүү тольд «үгийн язгуурын задлалтыг» голдож хийсэн бус үгийн бүтэц, язгуур үгийн задлалтыг ихэд анхаарсан бололтой. Үзэж харж ашиглах хүнд дөхмийг бодож монгол хэлний үүсмэл үндсийг ч мөн язгуурын нэгэн адилаар толгой үг болгон оруулжээ.

Толийн өмнөх үгэнд монгол хэлний үгийн язгуурыг хэрэглэгдэх байдлаар нь голдуу биеэ дааж хэрэглэгдэх буюу амьд ба биеэ дааж үл хэрэглэгдэх буюу заримдаг⁵ гэж хоёр хуваажээ. Манай судлаачид үгийн язгуурыг идэвхтэй, идэвхгүй хэмээн ангилдаг. Монгол хэлний үгийн анхдагч язгуур нь ихэвчлэн «ГЭ» (гийгүүлэгч-эгшиг) болон «Э» (эгшиг) бүтэцтэй гэж хуваадаг. Харин Монгол үгсийн язгуурын толь»-д үгийн язгуурыг голдуу үүсмэл язгуураар авч үзсэн тал харагдаж байна.

«Монгол үгсийн язгуурын толь»-д үгийн язгуурыг чухам яаж тайлж тайлбарласан, задалсан байдлыг тодруулах үүднээс «мал» гэсэн нэгэн үгээр жишээ татаж үзүүлбэл: «мал»-тэжээвэр адгуусны ерөнхий нэр, таван хошуу мал, бог мал, эд мал, мал аж ахуй, мал ахуй: уйгур, түргээр, эд малыг цөм мал гэнэ.

МАЛ малархаг, малархуу, маллах, маллагаа, малсаг, малч, малчин малжих, малжил, малжилгаа, малжилт⁶ гэх мэтээр мал гэсэн язгуураас үүсэх үгнүүдийг үүрлүүлэн оруулсан мөртлөө «малжи» гэсэн үйл үгийн үндсийг «мал»-ын үүсмэлд үз хэмээн зүүлт тайлбар хийж толгой үг болгожээ.

Монгол хэлний үгийн язгуур нь дагавар залгах аргаар цаашид үг бүтээдгээр үл барам авианы хувирал (нугарал, сэлгэлт, нэмэгдэл, хасагдал, ижилсэл, ондоошил)-аар үг бүтээдэг боломж байдгийг ч энэ тольд тусгасан байна. Тухайлбал: Би-на (би-ийн тийн ялгалт хэл бэр, солонгос хэлэнд на гэж би гэсэн утгаар хэрэглэгдэнэ), намайг, над: ба (би-ийн олон тоо), бид, биднийх зэргийг оруулснаас гадна манай, манайх, минь, миний, минийхлэх гэх мэт биеийн төлөөний үгийн уг язгуур нь «би» гэжээ.

Зохиогч «монгол хэлний дагавар» дэд хэсэгтээ үг бүтээх 544 зүйл дагаврыг оруулсан бол үг хувилгах дагаварт үндсэн тийн ялгал, үндсэн бус тийн ялгал, нөхцөл үйл үгийн хэлбэр, үйл, үгийн хувийн дагавар, тэмдэг үйл үгийн зэрэг 300 шахам дагаврыг хамруулж, нийтдээ Монгол хэлний 800 гаруй залгавар бүтээврийг монгол төрөл хэл болон алтай язгуурын хэлтэй дүйлгэн харьцуулан гарал үүслийг нь гаргаж тайлбарласан байна.

«Монгол үгсийн язгуурын толь» бүтээл нь монгол үгийн бүтцийг учир тодорхой болгоход зориулсан толгой үгийн утгыг товч тайлбарласан, холбогдох жишээг эх материалаас авсан, салаа утгыг зүйлчлэн ялгасан, үгийг бүтээвэр дагавраар задалсан, үгийн гарлыг тайлсан өвөрмөц нэгэн зүйл толь бичиг болж чадсаныг тэмдэглэлтэй.

Э. ПҮРЭВЖАВ. Р. БЯМБАА

1. Ч.Догсүрэн. Монгол нэр томъёо оноох, толилох, жигдлэх асуудалд. УБ., 1988, х, 47
2. П. Бямбасан. Монгол хэлний үгийн язгуур, үндсийн тухай зарим асуудалд. — «Хэл зохиол судлал», IX боть, 1972, х, 7
3. Ш, Лувсанвандан. Орчин цагийн монгол хэлний бүтэц. УБ., 1968, х, 99
4. Сэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь, 1988, х, 1
5. Мөн тэнд, х. 6
6. Сэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь, 1988, х. 1372